

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээсэн этгээдүүдээс Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны мэдээллийн санд ирүүлэх мэдээллийн төрөл, ирүүлэх хуваарь, түүнийг боловсруулах, хянах, ашиглах, хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэдээлэл ирүүлэх үүрэгтэй этгээд нь энэхүү журамд заасан мэдээллийг үнэн зөвөөр, тогтоосон хугацаанд энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд бичгэн болон цахим [/moh@frc.mn/](mailto:moh@frc.mn) хэлбэрээр Хороонд ирүүлнэ.

1.3. Хөрөнгийн зах зээлийн салбарын мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, хянах, ашиглах үүргийг Үнэт цаасны газар, мэдээллийг нэгдсэн серверт хадгалах, найдвартай байдлыг хангах үүргийг Хорооны Мэдээллийн технологийн хэлтэс тус тус хариуцна.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. “мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар Хорооны мэдээллийн санд мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээсэн этгээдийг;

1.4.2. “мэдээллийн сан” гэж мэдээллийн санд мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээсэн этгээдээс тус Хорооны хөрөнгийн зах зээлийн мэдээллийн санд энэ журмаар тогтоосон хугацаанд ирүүлсэн арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өөрийгөө зохицуулах байгууллага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөдөө аж ахуйн арилжаа, төлбөр, тооцоо, хөрөнгө оруулалтын сан, кастодиан, брокер, дилер, андеррайтерийн үйлчилгээний талаарх мэдээллүүдийг;

1.4.3. “хөрөнгийн зах зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан” гэж Үнэт цаасны газрын Бүртгэл, зөвшөөрлийн болон Бодлого, зохицуулалтын нэгжийн мэдээллийн санг хариуцан ажиллахаар үүрэг хүлээсэн ажилтанг;

1.4.4. “мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн мэдээллийн сан хариуцсан ажилтан” гэж мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн дотоод хяналтын ажилтныг, Үнэт цаасны

арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламж, өөрийгөө зохицуулах байгууллагын хувьд мэдээллийн албаны ажилтныг тус тус ойлгоно.

Хоёр. Мэдээллийн төрөл, ирүүлэх хуваарь

2.1. Мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн дотоод хяналтын болон мэдээллийн сангийн ажилтан нь энэхүү журмын хавсралт дахь маягтад заасан өөрийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг Хороонд ирүүлэх үүрэгтэй.

2.2. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11 дэх заалтад заасан арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан “МС-1” маягтад заасан сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ. /“Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын үнэт цаасны бирж” ХХК/

2.3. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.7, 24.1.8 дэх заалтад заасан төлбөр тооцооны тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан “МС-2” маягтад заасан сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ. /“Арилжааны төлбөр тооцоо” ХХК, “Монголын үнэт цаасны бирж” ХХК/

2.4. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.9 дэх заалтад заасан хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд нь энэ журмын гуравдугаар хавсралтад заасан “МС-3” маягтад заасан сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ. /“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/

2.5. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.3, 24.1.4, 24.1.5, 24.1.12, 24.1.13 дахь заалтад заасан брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежмент, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын зургаадугаар хавсралтад заасан “МС-5” маягтад заасан сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн /дараа улирлын 10-ны өдрийн/ дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ.

2.6. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.10 дахь заалтад заасан кастодианы тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан “МС-5” маягтад заасан сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн /дараа улирлын 10-ны өдрийн/ дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ.

2.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь энэ журмын долоодугаар хавсралтад заасан “МС-6” маягтад заасан улирал болон сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн /дараа улирлын 10-ны өдрийн/ дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ.

2.8. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн дагуу

хөдөө аж ахуйн бирж нь энэ журмын наймдугаар хавсралтад заасан “МС-7” маягтад заасан улирал болон сарын мэдээллийг дараа сарын эхний 10-ны өдрийн дотор болон дараа улирлын 10-ны өдрийн дотор цаасаар болон цахим хаягаар ирүүлнэ.

2.9. Мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн дотоодын хяналтын болон мэдээллийн сан хариуцсан ажилтан нь энэхүү журмын 2.2-2.8-д заасан хуваарийн дагуу мэдээллийг Хорооны мэдээллийн санд ирүүлэхээс гадна холбогдох мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 өдөрт багтааж тухай бүр шинэчлэн ирүүлнэ.

Гурав. Мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, боловсруулах, хяналт тавих

3.1. Үнэт цаасны газрын хөрөнгийн зах зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан нь мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдээс ирүүлсэн мэдээллийг доорх хэлбэрээр хянаж, баталгаажуулна.

- 3.1.1 мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд гаргаж ирүүлсэн эсэх;
- 3.1.2 тухайн мэдээллийг өмнө нь өгч байсан бол түүнтэй нийцэж буй эсэх;
- 3.1.3 мэдээллийг маягтын дагуу бүрэн ирүүлсэн эсэх;
- 3.1.4 шаардлагатай гэж үзсэн бусад ажиллагаа.

3.2. Үнэт цаасны газрын хөрөнгийн зах зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан нь ирүүлсэн мэдээллүүдийг энэхүү журмын 3.1-д заасны дагуу хянан, баталгаажуулж, цахим санд оруулахаас гадна цаасаар болон цахимаар ирүүлсэн мэдээллийг Хяналт шалгалт, зохицуулалтын газрын тухайн этгээдийг хариуцсан хянан шалгагчид ажлын 5 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

3.3. Мэдээллийн санд ирүүлсэн мэдээлэлтэй холбоотой хяналтыг Хяналт, шалгалт, зохицуулалтын газрын мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийг хариуцсан хянан шалгагч гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт, шалгалтыг удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

3.4. Маягтын дагуу гаргаагүй, бүрдэл дутуу ирүүлсэн тохиолдолд уг мэдээллийг ирүүлсэнд тооцогүй бөгөөд энэ талаар албан бичгээр мэдэгдэж дахин ирүүлэхийг шаардана.

3.5. Хорооны Ажлын албанаас мэдээлэл ирүүлэх тухай албан бичгээр өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй эсхүл мэдээллийг бүрдэл дутуу ирүүлсэн тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан захиргааны хариуцлагыг хүлээлгэнэ.

Дөрөв. Мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг ашиглах

4.1. Хөрөнгийн зах зээлийн цахим мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг салбарын тойм мэдээлэл гаргах, статистик эконометрикийн судалгаа шинжилгээ хийх, салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг

хэрэгжүүлэх зорилгоор дотроо ашиглана.

4.2. Хөрөнгийн зах зээлийн цахим мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг энэхүү журмын 4.1-д зааснаас бусад хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

4.3. Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, шүүх, прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлагын бичгээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд мэдээллийн сангаас холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

4.4. Энэ журмын 4.3-д зааснаас гадна Хорооны мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийг харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, Хорооны мэдээллийн албаны удирдлагын гаргасан хүсэлтээр холбогдох мэдээллийг хүргүүлж болно.

4.5. Үнэт цаасны газрын бодлого, зохицуулалтын нэгжээс хөрөнгийн зах зээлийн мэдээллийн санд ирсэн мэдээллийг эмхэтгэн улирал бүр Хорооны удирдлага, Судалгаа, шинжилгээний хэлтэст цахимаар хүргэх бөгөөд салбарын бодлогыг боловсруулахтай холбоотойгоор салбарын нөхцөл, байдлын талаарх танилцуулгыг Хорооны хуралдаанд танилцуулна.

Тав. Мэдээллийн сан дахь мэдээллийн хадгалалт

5.1. Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийг цахим хэлбэрээр Хорооны нэгдсэн мэдээллийн санд, цаасан хэлбэрээр ирсэн мэдээллийг мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн хувийн хэрэгт тус тус хадгална.

5.2. Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг Үнэт цаасны газрын мэдээллийн сангийн ажилтан болон Мэдээлэл, технологийн хэлтэс тус тус хариуцна.

Зургаа. Хариуцлага

6.1. Мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн дотоод хяналтын болон мэдээллийн сан хариуцсан ажилтан нь энэхүү журмаар мэдээллийн санд ирүүлэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, зохих маягтын дагуу, үнэн зөвөөр, бүрэн ирүүлээгүй тохиолдолд мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно

6.2. Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн нь тогтоогдвол буруутай этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх, эсхүл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-1"

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Үзүүлэлтүүд	Сар бүр	Өссөн дүн
1	Арилжаа явагдсан өдөр		
2	Үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн тоо Үүнээс: Төрийн өмчийн Төрийн өмчийн оролцоотой Хувийн өмчийн		-
3	Бүртгэлтэй үнэт цаасны нийт тоо ширхэг Үүнээс: Төрийн өмчийн Хувийн өмчийн		
4	Зах зээлийн нийт үнэлгээ /төгрөг/		-
5	Арилжааны төрөл Үүнээс: Энгийн арилжааны үнийн дүн /төгрөг/ Багцын арилжааны үнийн дүн /төгрөг/ Тендер саналын арилжаа үнийн дүн /төгрөг/ AON дуудлага арилжаа үнийн дүн /төгрөг/		
6	Анхдагч зах зээлийн үнэт цаасны гүйлгээний дүн /төгрөг/ Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд /хоёрдогч зах зээлд/ Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа /нэгж эрх/ Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		
7	Анхдагч зах зээлийн үнэт цаасны тоо ширхэг Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		

8	<p>Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн гүйлгээний дүн /төгрөг/ Үүнээс:Компанийн хувьцаа Засгийн газрын бонд /хоёрдогч зах зээлд/ Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</p>		
9	<p>Хоёрдогч зах зээлд арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг Үүнээс:Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</p>		
10	<p>Дундаж ханш Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</p>		
11	<p>ТОП-20 индекс Дундаж Хамгийн их Хамгийн бага Хаалт</p>		
12	<p>Арилжигдсан үнэт цаасны тоо Үүнээс: Ханш өссөн Ханш буурсан Ханш тогтмол</p>		
13	Хийгдсэн хэлцэл		

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-3"

ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЭЛ ИХТЭЙ ҮНЭТ ЦААС (ТУХАЙН САРД)

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ҮНЭТ ЦААС

№	Үнэт цаас	Арилжагдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ҮНЭТ ЦААС

№	Үнэт цаас	Арилжагдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-8"

**ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ БҮРДҮҮЛЭГЧ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /САРААР/**

№	Компанийн нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тухайн сарын хаалтын ханш	Зах үнэлгээ

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-9"

**АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ИНДЕКСИЙН САГСАНД ОРСОН КОМПАНИЙН
МЭДЭЭЛЭЛ /САРААР/**

№	Компанийн нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тухайн сарын хаалтын ханш	Зах зээлийн үнэлгээ

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-10"

Арилжааны шимтгэл	Арилжааны дүн	Худалдах захиалгын шимтгэл	Худалдан авсан захиалгын шимтгэл	Тухайн сард арилжаа эрхлэх байгууллагын дансанд төвлөрсөн шимтгэлийн орлогын дүн /төгрөгөөр/
	Жишээ нь <1,000,000,000 /нэг тэрбум төгрөг хүртэл/	0.2 хувь	0.4 хувь	
	>1,000,000,000 /нэг тэрбум төгрөгөөс дээш бол/	0.15 хувь	0.35 хувь	

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-11"

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ

№	Салбарын ангилал	Өөрчлөлтийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Өсөлт, бууралт /хувиар/
	Үнэлгээ буурсан салбар	Барилгын салбар	
		Уул уурхайн салбар	
		Үйлчилгээ	
		Харилцаа холбоо гэм мэт	
	Үнэлгээ өссөн салбар	Үйлдвэрлэл	
		Үл хөдлөх хөрөнгө	
		Хөдөө аж ахуй гэх мэт	
	Нийт дүн		

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-12"

ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлтүүд	Тоо хэмжээ /ширхэгээр/
	Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ хүргүүлсэн хувьцаат компани	
	Санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээлсэн компани	
	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлан хуралдуулсан компанийн тоо	
	Хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээ томилсон компани	

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Маягт МС-1-13"

АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл
	Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
	Тусгай зөвшөөрлийн огноо, Дугаар	
	Байгуулагдсан огноо, шийдвэр	
	Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
	Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
	ТУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	ТУЗ-ийн гишүүд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	5. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	6. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	7. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	8. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Гүйцэтгэх захирал: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Албадын захирлууд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын хоёрдугаар хавсралт "Маягт МС-2-5"

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ
/ХУВИЙН ТАРААЛТЫН ТАЙЛАН**

№	Компанийн нэр	Хувьцааны тоо		Ногдол ашиг/ хувийн хэмжээ /нэгж хувьцаанд,төг/		ногдол ашиг/ хувь авах эрхтэй хувьцаа ээмшигчийн тоо	Тараасан хэлбэр			үлдлгдэл
		нийт гаргасан	ногдол ашиг /хувь/	нэгж хувьцаа	нийт		лансанд байршуулсан	БДК-р	Компаниар	

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын хоёрдугаар хавсралт "Маягт МС-2-6"

**ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАХ ЗОРИЛГООР ЗЭЭЛИЙН БАРЬЦААНД
ТУСГААРЛАСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭ**

зээлдэгчийн нэр		
зээлдүүлэгчийн нэр		
барьцаалсан үнэт цаас	КОД	
	нэр	
	тоо	
	КОД	
	нэр	
	тоо	
	КОД	
	нэр	
	тоо	
зээлийн	ХЭМЖЭЭ	
	хугацаа	
	хүү	

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам”-ын хоёрдугаар хавсралт “Маягт МС-2-7”

**ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРЭЭР ҮНЭТ ЦААС
ТУСГААРЛАСАН БОЛОН ЧӨЛӨӨЛСӨН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Огноо	Тусгаарласан болон чөлөөлсөн үнэт цаасны нэр	Үнэт цаасны эзэмшигчийн			Тоо ширхэг	Шимтгэл	Тайлбар
		Овог нэр	Регистр	Дансны дугаар			

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам”-ын хоёрдугаар хавсралт “Маягт МС-2-8”

**ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ХАДГАЛАГДАЖ БУЙ ҮНЭТ ЦААС
/МЯНГАН ШИРХЭГ/**

Үзүүлэлт	Тухай сард	Өссөн дүн	
Төрийн мэдлийн бус хувьцаа			
Төрийн мэдлийн хувьцаа			
Орон нутгийн оролцоотой компани			
Нийт хувьцааны дүн			
Засгийн газрын хямдруулсан бонд			
Компанийн бонд			
Нийт бондын дүн			
Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас /мянган ширхэгээр/			
Компанийн бонд			
Засгийн газрын хямдруулсан бонд			

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам”-ын хоёрдугаар хавсралт “Маягт МС-2-9”

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл
	Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
	Тусгай зөвшөөрлийн огноо, Дугаар	
	Байгуулагдсан огноо, шийдвэр	
	Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
	Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
	ТУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	ТУЗ-ийн гишүүд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	5. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	6. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	7. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	8. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Гүйцэтгэх захирал: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Албадын захирлууд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан
“Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам”-ын гуравдугаар хавсралт “Маягт МС-3-1”

ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХЬ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭ,
ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭЛЭЛ (мян.төг)

		Тухайн сард	Өссөн дүн
1	Төвлөрсөн хадгаламжийн дансаар хийгдсэн орлогын гүйлгээ Үүнээс: Харилцагчийн тоо Дансны гүйлгээ /удаа/ Үнийн дүн /төгрөг/		-
2	Төвлөрсөн хадгаламжийн дансаар хийгдсэн зарлагын гүйлгээ Үүнээс: Харилцагчийн тоо Дансны гүйлгээ /удаа/ Үнийн дүн /төгрөг		
3	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны гүйлгээ /төгрөгөөр/ Үүнээс: ХААН банк Голомт банк ХАС банк Худалдаа хөгжлийн банк		

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан
 “Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам”-ын дөрөвдүгээр хавсралт
 “Маягт МС-4-1”

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
 ЯВУУЛЖ БУЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

№	Байгууллагын нэр	
1.	Үүсгэн байгуулагдсан огноо	
2.	Компанийн улсын бүртгэлийн болон гэрчилгээний дугаар	
3.	Гадаадын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгж бол гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар	
4.	Тусгай зөвшөөрөл олгосон тогтоолын дугаар, гэрчилгээний дугаар	
5.	Үнэт цаасны арилжаа эрхлэх ямар байгууллагын гишүүн болох	
6.	Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээний төрөл, явуулсан хугацаа	
7.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь, нэрлэсэн үнэ	
8.	Орон нутагт салбар үйл ажиллагаа эрхэлдэг эсэх / аймаг, сум/	
9.	Нийт харилцагчийн тоо	
10.	ТУЗөвлөлийн дарга, гишүүдийн танилцуулга, /овог нэр, гэрийн хаяг, утас, e-mail /мэргэжил, ажлын туршлага	
11.	Гүйцэтгэх захиралын танилцуулга: /овог нэр, мэргэжлийн үнэмлэхийн дугаар, дуусах хугацаа, утас, e-mail мэргэжил, өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал	
12.	Компанийн хаяг байршил, холбоо барих утас, цахим хаяг,	
13.	Сүүлийн 3 жилд арилжааны хэлцэл буцаагдаж байсан эсэх. / тийм, үгүй аль нэгийг сонгох ямар шалтгаанаар буцаагдсан талаар тайлбар бичих.	
14.	Сүүлийн 3 жилд Хороо, Хөрөнгийн биржээс компани болон ажилтанд хариуцлага хүлээлгэж байсан эсэх. / хүлээлгэсэн огноо, шийтгэлийн төрөл, ямар зөрчилд оногдуулсан тайлбар/	

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4-3"

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Үйлчлүүлэгчийн нэр	Үзүүлэхээр гэрээ байгуулсан үйлчилгээний хэлбэр	Бусад этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан бол	
		Хамтран ажиллах чиглэл	Этгээдийн нэр

Андеррайтерийн үйлчилгээний гэрээний биелэлтийн тухай мэдээлэл:

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4-4"

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ААН	Үйлчилгээний төлбөрийн хэмжээ	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн иргэн	Үйлчилгээний төлбөрийн хэмжээ

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4-5"

ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Худалдан авсан			Худалдсан		
Үнэт цаасны нэр	тоо	үнийн дүн	Үнэт цаасны нэр	тоо	үнийн дүн

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4-6"

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТНУУДЫН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

	Эрх бүхий албан тушаалтан, ажилтны овог нэр	албан тушаал	төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар	Холбогдох этгээдүүдийн /эхнэр, нөхөр, хүүхэд гэх мэт/ овог,нэр	төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар
1		ТУЗ-ийн дарга, гүшүүд			
2		Гүйцэтгэх захирал			
3		Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх гэм мэт			

Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан ажилтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх болон бусад захирлууд, газар хэлтэс, тасаг албадын дарга нар салбар төлөөлөгчийн газрын дарга нар, ажилтанд брокер, дилер, нягтлан бодогчоор ажиллаж буй хүмүүс хамаарна

*Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4-7"*

КОМПАНИЙН САЛБАР /ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР/ -ИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Код	Компанийн нэр	Үйлчилгээ үзүүлэх эрхтэй орон нутаг	Компанийн үндсэн хаяг, утас	Салбарын хаяг	Салбарын захирлын нэр, холбоо барих утас	Брокерийн нэр, холбоо барих утас

*Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4-8"*

ЗОХИЦУУЛАЛТАЙ ЭТГЭЭДИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ /Сараар/

№	Хураангуй баланс, тайлангийн үзүүлэлтүүд	Үзүүлэлт /өссөн дүнгээр төгрөгөөр/
1	Нийт хөрөнгө	
2	Эргэлтийн хөрөнгө	
3	Эргэлтийн бус хөрөнгө	
4	Богино хугацаат өр төлбөр	
5	Урт хугацаат өр төлбөр	
6	Нийт өр төлбөр	
7	Хувь нийлүүлсэн хөрөнгө	
8	Эзэмшигчдийн өмч	
Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлтүүд		
9	Нийт орлого	
10	Нийт зардал	
11	Цэвэр ашиг	

*Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт
"Маягт МС-4-9"*

**ГАДААД УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН
АВАХАД ЗУУЧЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БРОКЕРИЙН
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/**

№	Брокерийн компанийн нэр	Зөвшөөрөл олгосон тогтоолын дугаар	Гадаадын зуучлагч брокерийн компани	Арилжаа хийгдсэн бирж	Харилцагчийн тоо	Арилжаа хийгдсэн валют, төгрөгөөр

*Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт
"Маягт МС-4-10"*

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН
МЭДЭЭЛЭЛ**

Удирдаж байгаа сангийн		Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрчлөлт орсон байдал /тайлбар бичнэ/
Цэвэр актив /төгрөгөөр/	Активын цэвэр өртгийн хэмжээ /төгрөгөөр/	

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт
"Маягт МС-5-11"

ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт		Харилцагчдын тоо	
Харилцагч	Иргэн	Гадаад	
		Дотоод	
	Аж ахуйн нэгж	Гадаад	
		Дотоод	
Нийт харилцагчдын тоо			

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын нэгдүгээр хавсралт
"Маягт МС-5-12"

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ХӨРӨНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд			Төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
Харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас	Хувьцаа	Нээлтэй ХК	Дотоод		
			Гадаад		
		Хаалттай ХК	Дотоод		
			Гадаад		
		ЗГҮЦ	Дотоод		
			Гадаад		
		Компанийн өрийн хэрэгсэл	Дотоод		
			Гадаад		
Орон нутгийн өрийн хэрэгсэл	Дотоод				
	Гадаад				
Мөнгөн хөрөнгө	Үндэсний валют	Төгрөг	MNT		
	Гадаад валют	Ам.Доллар	USD		
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Үнэт цаас	Барьцаат			
		Баталгаат			
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	Гэрээнүүд	Зохицуулалттай зах зээл	Фьючерс, Опцион, варрант		
		Биржийн бус зах зээл	Форвард, Своп, опцион		
Уул уурхайн бүтээгдэхүүн	Үнэт металл	Алт, мөнгө	Унц		
	Бусад	Арилжаалах боломжтой	Тонн		
Үл хөдлөх эд хөрөнгө	Эзэмших эрх	Гэрчилгээ			

Санхуугийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын тавдугаар хавсралт
"Маягт МС-6-1"

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлтүүд	Улирал
1	Баталгаат үнэт цаасны нийт хэмжээ Үүнээс:	
1.1	Энгийн баталгаат үнэт цаас /төг./	
1.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /төг./	
2	Баталгаат үнэт цаасны тоо Үүнээс:	
2.1	Энгийн баталгаат үнэт цаас /ширхэг/	
2.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /ширхэг/	
3	Баталгаат үнэт цаасны жилийн хүү Үүнээс	
3.1	Энгийн баталгаат үнэт цаас /хувь/	
3.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /хувь/	
4	Баталгаат үнэт цаасны үндсэн төлбөрийн дүн	
4.1	Энгийн баталгаат үнэт цаас /төг./	
4.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /төг./	
5	Баталгаат үнэт цаас гаргагчийн тоо	
6	Зээлдэгчийн тоо	
7	Барьцаат хөрөнгийн үнэлгээ	
7.1	Үндсэн барьцаат хөрөнгийн үнэлгээ	
7.2	Нэмэлт барьцаат хөрөнгийн үнэлгээ	
8	Барьцаат хөрөнгийн тоо	
8.1	Үндсэн барьцаат хөрөнгийн тоо	
8.2	Нэмэлт барьцаат хөрөнгийн тоо	

Санхуугийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын тавдугаар хавсралт
"Маягт МС-6-2"

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ ХОРООНД БҮРТГҮҮЛСЭН БАРЬЦААТ ХӨРӨНГИЙН ТОО АЙМАГ, ДҮҮРГЭЭРЭЭ

№	Он	Улирлаар
1	Нийт хөрөнгийн тоо	
2	Баруун бүсийн аймгууд	
3	Хангайн бүсийн аймгууд	
4	Төвийн бүсийн аймгууд	

5	Зүүн бүсийн аймгууд	
6	Улаанбаатар хот дүүргүүдээр	

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын тавдугаар хавсралт
"Маягт МС-6-3"

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ
/Тусгай зориулалтын компаниар/

Үнэт цаас гаргагч	Нийт гаргасан Баталгаат үнэт цаас /тэрбум төгрөг/	"ҮЦТХТ" ХХК-д Бүртгэгдсэн үнэт цаас /тэрбум төгрөг/	Зээлдэгчийн тоо	Тайлант хугацааны үлдэгдэл /тэрбум төгрөг/	Төлөгдсөн үндсэн төлбөр /тэрбум төгрөг/

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын тавдугаар хавсралт
"Маягт МС-6-4"

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/	Эзлэх хувь
Энгийн баталагаат үнэт цаас						
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас						
Нийт						

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан"
Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын тавдугаар хавсралт
"Маягт МС-6-5"

№	Анхны үүрэг гүйцэтгэгч	Зээлийн багц хөрөнгө /төгрөгөөр/	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ	Зээлийн дансдын тоо

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ТАНИЛЦУУЛГА

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл
	Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
	Байгуулагдсан огноо, шийдвэр	
	Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
	Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
	ТУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	ТУЗ-ийн гишүүд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	5. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	6. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	7. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	8. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Гүйцэтгэх захирал: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	Албадын захирлууд:	
	1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
	4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

Санхүүгийн зохицуулах хорооны оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан" Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ын зургаадугаар хавсралт "Маягт МС-7-4"

	Арилжааны дүн	Худалдах захиалгын шимтгэл	Худалдан авсан захиалгын шимтгэл	Тухайн сард арилжаа эрхлэх байгууллагын дансанд төвлөрсөн шимтгэлийн орлогын дүн /төгрөгөөр/
Арилжааны шимтгэл	Жишээ нь <1,000,000,000 /нэг тэрбум төгрөг хүртэл/	0.2 хувь	0.4 хувь	
	>1,000,000,000 /нэг тэрбум төгрөгөөс дээш бол/	0.15 хувь	0.35 хувь	